

## “Count the Kicks” Нууцын журам

Таны нууц бидэнд чухал. Уг нууцын журмыг ‘Хувь хүнийг таньж болохуйц мэдээлэл’ (ХХТБМ)-г нь онлайнаар хэрхэн ашиглаж буй талаар санаа зовниж буй хүмүүс илүү ойлгомжтой үйлчлэх зорилгоор шинэчлэн нэгтгэлээ. АНУ-ын нууцын тухай хууль болон мэдээллийн хамгааллын дагуу ХХТБМ гэдэг нь дангаар нь эсвэл өөр бусад мэдээлэлтэй хослуулан ашиглаад тухайн хүний хэн болохыг тогтоох, холбоо барих эсвэл байршлыг нь тогтоох боломжтой мэдээллийг хэлнэ. Манай нууцын журмыг сайтар уншиж, бид Хувь хүнийг таньж болохуйц мэдээллийг өөрийн цахим хуудас болон “Count the Kicks” апп-ын хүрээнд хэрхэн цуглуулж, ашиглаж, хамгаалах буюу бусад хэлбэрээр харьцдаг тухай илүү тодорхой ойлголт аваарай.

### **Манай цахим хуудас болон “Count the Kicks” апп руу холбогдсон хүмүүсийн талаар ямар хувийн мэдээллийг бид цуглуулдаг вэ?**

Та манай апп дээр зохих ёсоор хувийн хэрэг үүсгэхэд таны ашиглах явцад туслах зорилгоор бид таны нэр, э-мэйл хаяг, шуудангийн код, утасны дугаар эсвэл бусад мэдээллийг оруулахыг хүсэж болно.

Та манай цахим хуудаснаа зохих ёсоор хандив өгөх эсвэл материал захиалахад тэдгээр үйл явцад туслах зорилгоор болон танд мэдээлэл материал илгээх зорилгоор бид танаас өөрийн нэр, э-мэйл хаяг, шуудангийн хаяг, утасны дугаар эсвэл бусад мэдээллийг оруулахыг хүсэж болно.

### **Бид хэзээ мэдээлэл цуглуулдаг вэ?**

Та манай цахим хуудас эсвэл апп дээр хувийн хэрэг үүсгэх буюу мэдээлэл оруулах үед, мөн түүнчлэн SMS зурваст нэгдэн ороход тань бид танаас мэдээлэл цуглуулах болно.

### **Бид таны мэдээллийг хэрхэн ашигладаг вэ?**

Таныг хувийн хэрэг үүсгэх, манай мэдээ мэдээллийг захидлаар хүлээн авахаар бүртгүүлэх, SMS зурваст нэгдэн ороход, судалгаа эсвэл маркетингийн харилцаанд хариу өгөхөд эсвэл цахим хуудас дээрх өөр бусад үзүүлэлтийг ашиглах явцад бидний танаас цуглуулсан мэдээллийг бид дараах байдлаар ашиглаж болно:

- Танаас ирүүлсэн хэрэглэгчийн үйлчилгээний хүсэлтэд илүү сайн үйлчлэх боломжийг бидэнд олгох зорилгоор
- Таны ашиглалтын явцыг илүү хувь хүнд тань нийцүүлэх болон таны хамгийн их сонирхож буй контентын төрлийг танд хүргэх боломжийг бүрдүүлэх зорилгоор
- Урамшуулал зарлах, судалгаа явуулах эсвэл цахим хуудасны бусад үзүүлэлтийг явуулах зорилгоор
- Үйлчилгээ болон бүтээгдэхүүнд маань үнэлгээ өгөхийг танаас хүсэх зорилгоор
- Захидал харилцааны дараа тантай эргэн холбогдох зорилгоор (э-мэйл, текст, эсвэл утсаар ирүүлсэн лавлагаа)

### **Бид таны мэдээллийг хэрхэн хамгаалах вэ?**

Манай цахим хуудаснаа таны ашиглалт хандалтыг аль болох аюулгүй байлгах зорилгоор ямар нэг аюулгүй хамгааллын цоорхой болон мэдэгдэхүйц эрсдэл байгаа эсэхийг нягтлан бид тогтмол шалгалт хийдэг. Бид Malware Scanning тогтмол ашиглаж тус шалгалтыг үйлддэг.

Таны хувийн мэдээлэл хамгаалагдсан сүлжээний цаана хадгалагддаг бөгөөд түүнд зөвхөн тэдгээр системд хандах тусгай эрхтэй цөөн тооны хүмүүс хандах боломжтой ба тэд мэдээллийн нууцыг чандлан сахих үүрэгтэй. Хэрэглэгч нэвтрэх, өөрийн мэдээллийг оруулах эсвэл түүнд хандах явцад таны хувийн мэдээллийн аюулгүй хамгааллыг хангах зорилгоор бид төрөл бүрийн хамгааллын арга хэмжээ авдаг.

Бүх гүйлгээг гарц нийлүүлэгчээр дамжуулан боловсруулдаг ба тэдгээр нь манай сервер дээр хадгалагдахгүй буюу боловсруулагдахгүй.

### **Гуравдагч этгээдэд задруулах**

Бид таны Хувь хүнийг таньж болохуйц мэдээллийг худалддаггүй, солилцдоггүй, буюу өөр бусад хэлбэрээр гаднын этгээдэд дамжуулдаггүй.

### **Гуравдагч этгээдийн холбоос**

Заримдаа бид өөрийн үзэмж шийдвэрээр апп дээрээ гуравдагч этгээдийг бүтээгдэхүүн, үйлчилгээг оруулах буюу санал болгож болно. Эдгээр гуравдагч этгээдийн цахим хуудас нь тус тусын бие даасан нууцын журамтай. Тийм учраас бид тэдгээр холбосон холбооснууд дээрх контент болон үйл ажиллагааг хариуцахгүй буюу хариуцлага хүлээхгүй. Гэхдээ, бид өөрийн цахим хуудасны бүрэн бүтэн байдлыг хамгаалахыг эрмэлздэг ба эдгээр цахим хуудасны талаарх аливаа мэдээллийг таатай хүлээж авна.

### **Европын Мэдээллийн өгөгдлийг хамгаалах ерөнхий журам (МӨХЕЖ)**

МӨХЕЖ нь 2018 оны тавдугаар сарын 25-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба энэ нь бидний Европын Холбооны хэрэглэгчидтэйгээ харилцах харилцааг зохицуулдаг. Бид МӨХЕЖ-ыг хэрэгжүүлэх зорилгоор дараах алхмуудыг авч хэрэгжүүлсэн:

- Энэ нууцын журмыг МӨХЕЖ-ын дагуу шинэчилсэн.
- Өөрийн э-мэйлийн жагсаалт дахь хаяг руу эдгээр өөрчлөлтийн талаар мэдээлсэн э-мэйл илгээсэн.
- Бид Европын мэдээллийн өгөгдлийн нууцын зөрчлийн талаар ЕХ-ны холбогдох эрх бүхий байгууллагад 72 цагийн дотор мэдээлнэ.
- Хамгаалалтын шилдэг программыг ашиглан систем, өгөгдлийг хамгаалах шаардлагыг мөрдсөн.
- Бид хувийн мэдээлэлдээ хандах, түүнийг өөрчлөх, устгах, танах хувь хүний эрхээ эдлэх хүсэлтийг хүлээн авах чадамжтай. Та хүссэн цагтаа өөрийн мэдээллийн өгөгдлийг бүрмөсөн устгах хүсэлт ирүүлэх боломжтой. Хэрэв та өөрийн мэдээллийн өгөгдлийг устгуулах хүсэлт илгээх бол
- Бид хувийн мэдээллийн өгөгдөлд нь хийх боловсруулалтыг хязгаарлах, түүнийг эсэргүүцэх болон хувийн мэдээллийн өгөгдөлд зөвхөн автоматаар хийсэн боловсруулалтад үндэслэсэн аливаа шийдвэрийг эсэргүүцэх хувь хүний хүсэлтийг хүлээн авах чадамжтай.

## **Калифорни мужийн онлайн нууцын хамгаалалтын тухай хууль**

CalOPPA нь худалдааны цахим хуудас болон онлайн үйлчилгээ эрхлэгчдээс нууцын журам нийтлэхийг шаардсан үндэсний хэмжээнд анхны мужийн хууль юм. CalOPPA-гийн дагуу, бид дараахыг зөвшөөрч байна:

- Хэрэглэгчид манай апп-ыг нэрээ нууцлан ашиглах боломжтой.
- Та уг нууцын журмыг манай [www.countthekicks.org](http://www.countthekicks.org) цахим хуудаснаас харах боломжтой. Нууцын журмын аливаа өөрчлөлтийн талаар бид Нууцын журмын хуудсаараа дамжуулан танд мэдэгдэнэ.
- Хэрэглэгчид өөрийн хаягаар нэвтрэн орж хувийн мэдээллээ өөрчлөх боломжтой.

## **Манай цахим хуудас Do Not Track буюу Үл мөшгөх дохиог хэрхэн зохицуулдаг вэ?**

Бид Үл мөшгөх дохиог хүндэтгэдэг бөгөөд браузерт Do Not Track (DNT) механизм тохируулсан үед мөшгөхгүй, күүки байршуулахгүй буюу зар сурталчилгаа ашигладаггүй.

Бид гуравдагч этгээдийн зан байдлын мөшгөлтийг зөвшөөрдөггүй.

## **COPPA (Хүүхдийн онлайн нууцын хамгаалалтын тухай хууль)**

13 нас хүрээгүй хүүхдийн талаарх хувийн мэдээлэл цуглуулах тухайд Хүүхдийн онлайн нууцын хамгаалалтын тухай хууль (ХОНХТХ) эцэг эхэд хяналтыг өгдөг. АНУ-ын хэрэглэгчийг хамгаалах агентлаг болох Холбооны худалдааны комисс нь ХОНХТХ дүрмийг хэрэгжүүлдэг ба уг дүрэмд цахим хуудас болон онлайн үйлчилгээ эрхлэгчид хүүхдийн нууц болон аюулгүй байдлыг онлайн аар хамгаалах чиглэлээр юу хийх ёстойг заадаг.

Бид 13 нас хүрээгүй хүүхдэд тусгайлан чиглэсэн үйлчилгээ үзүүлдэггүй.

## **Шударга мэдээллийн дадал**

Шударга мэдээллийн дадал зарчим АНУ-ын нууцын хуулийн үндсэн үзэл баримтлал байдаг ба түүнд багтсан ойлголтууд дэлхий дахины мэдээллийн өгөгдөл хамгааллын хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Шударга мэдээллийн дадал зарчмыг болон тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар ойлгох нь хувийн мэдээллийг хамгаалах зорилготой төрөл бүрийн нууцын хуулийг хэрэгжүүлэхэд нэн чухал.

Шударга мэдээллийн дадлыг хэрэгжүүлэхийн тулд хэрэв мэдээллийн өгөгдлийн зөрчил гарсан тохиолдолд бид танд ажлын 1 өдөрт багтаан мэдэгдэл хүргүүлэх болно.

Бид түүнчлэн уг хуулийг хэрэгжүүлээгүй мэдээллийн өгөгдөл цуглуулагч болон боловсруулагчийн эсрэг хууль эрхзүйн хувьд хэрэгжүүлж болохуйц эрхээ эдлэх боломж өгөхийг шаардсан Хувь хүний гомдлыг барагдуулах зарчмыг бид зөвшөөрч байна. Түүнчлэн уг зарчмын хүрээнд мэдээллийн өгөгдлийн хэрэглэгчдийн эсрэг хэрэгжүүлж болохуй эрх эдлэхийг шаардахын зэрэгцээ мэдээллийн өгөгдлийг боловсруулахдаа хууль сахиагүй үйлдлийг мөрдөн шалгах болон/эсвэл шүүн шийдвэрлэх чиглэлээр шүүхийн байгууллага эсвэл төрийн агентлаг хандах боломж бүрдүүлэх ёстой.

## **CAN SPAM буюу Спам боломжтой тухай хууль**

CAN-SPAM хууль худалдааны захидлын чиглэлээр дүрмийг тусгасан байдаг ба худалдааны мессежинд тавигдах шаардлагыг тогтоож, хүлээн авагчдад тэдгээр э-мэйлийг тэдэнд илгээхийг зогсоох хүсэлт тавих эрхийг олгож, үүнийг зөрчсөн тохиолдолд хатуу чанга шийтгэл ногдуулахыг заасан байдаг.

Бид таны э-мэйл хаягийг дараах зорилгоор цуглуулдаг:

- Мэдээлэл илгээх, лавлагаанд хариу өгөх, болон/эсвэл бусад хүсэлт эсвэл асуултад хариулах
- Э-мэйлийн жагсаалтын хаягууд руу маркетингийн мэдээлэл хүргэх эсвэл анхны гүйлгээ хийгдсэний дараа өөрийн харилцагчдадаа үргэлжлүүлэн э-мэйл илгээх.

CANSPAM хуулийн хэрэгжүүлэх хүрээнд бид дараахыг зөвшөөрч байна:

- Худал эсвэл буруу хүлээлт үүсгэх сэдэв эсвэл э-мэйл хаяг ашиглахгүй байх.
- Мессежийг хүлээн зөвшөөрөхүйц түвшинд зар сурталчилгаа гэж тодорхойлох.
- Өөрийн бизнесийн эсвэл төв байгууллагын биет хаяг байршлыг тусгах.
- Гуравдагч этгээдийн э-мэйл маркетингийн үйлчилгээнд, хэрэв байдаг бол, тус хуулийн хэрэгжилтийн хүрээнд хяналт тавих.
- Гарах/бүртгэлээ цуцлах хүсэлтийг шуурхай шийдвэрлэх хүндэтгэх.
- Э-мэйл бүрийн доор оруулсан холбоосоор дамжуулан хэрэглэгчдэд бүртгэлээ цуцлах боломж бүрдүүлэх.

Хэрэв та хэзээ нэгэн цагт ирээдүйд э-мэйл хүлээн авахаас татгалзан бүртгэлээ цуцлахыг хүсвэл бидэнтэй

[Бидэнтэй холбогдох](#)

Сүүлд засварласан огноо: 01-06-22